

СҮМЫН ИТХ-ЫН ДАРГА

БАТДАВ

Б.ГАНБАТ

2019 оны 06 дугаар сарын 10 өдөр

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ № 02

Энэхүү гэрээг нэг талаас **Өвөрхангай** аймаг .**Уянга** сумын Засаг дарга **Б.Доржтогоо** (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч . **АУМ-АЛТ ХХК**-ийг төлөөлж . **ӨЛТИЙН УУРХАЙН ДАРГА** ажилтай **Ж.Шийрэвдорж** нар (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 6 дугаар сарын 10 -ны өдөр **Өвөрхангай** аймаг **Уянга** суманд байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь **Өвөрхангай** аймгийн Уянга сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

### Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2. гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.3. энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсэний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;

2.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмерийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.3. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.1.4. нийт ажлын байрны 30 аас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;

3.1.5. өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;

3.1.6. хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн сумын иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

3.1.7. бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.1.8. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.9. гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

3.1.10 Туслан гүйцэтгэгчээр ажиллаж буй уул уурхайн аж ажуйн нэгжүүдийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хэрэгжүүлэхэд сумын нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах

3.1.11. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилтын хүрээнд:

- Байгууллагын орчныг тохижуулах, хог хаягдалаа устгах, сумын төвийн хог хаягдлыг зайлцуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Улс, аймаг, суманд төлөх татварыг хуулийн хугацаанд төвлөрүүлэх, тайланг хугацаанд нь гаргах
- Ажиллагсадаа эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлд бүрэн хамруулах
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, журмыг чанд мөрдөж ажиллах
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу бүрэн хийнэ.
- Аж ахуйн нэгжийн тайлангаа хугацаанд нь гарган тайлагнах.

- Холбогдох хууль тогтоомжийн биелэлтийн талаархи мэдээллийг шаадлагатай уед болон улирал бүр тайлагнах

3.1.11. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тесэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- Сумын Цагдаагийн тасгийн кабон байрны завсарт 15,0 /арван таван/ сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх 2019 оны 6 дугаар сарын 30 ны дотор/
- Соёлын төвд хөгжим техник хэрэгслээр хангахад 15,0 /арван таван/ ~~сая~~ төгрөгөөр дэмжих /2019 оны 6 дугаар сарын 30 ны дотор/
- Соёлын гавьяат зүтгэлтэн С.Мөнхдалайд хүндэтгэл үзүүлэх 3,5/ гурван сая таван зуу/ мянган төгрөгийн гэр бэлтгэх/ 2019 оны 7 дугаар сарын 05 ны дотор/

#### **Дөрөв. Хамтын ажиллагааны хороо**

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороог Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнэ.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

#### **Тав. Гэрээний хэрэгжилт**

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. .

5.2. Талууд гэрээний биелэлтийг 11 дугээр сарын 20 ны дотор дүгнэж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 20 -ний дотор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

#### **Зургаа. Гэрээний хариуцлага**

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

#### **Долоо. Маргаан шийдвэрлэх**

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг харилцан зөвшилцэж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

**Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох**

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш тухайн оны 12 дугаар сарын 31 ны өдрийг дуустал хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

НУТГИЙН ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ

УЯНГА СҮМЫН ЗАСАГ  
ДАРГА БДОРЖТОГОО



АШИГТ МАЛТМАЛЫН

БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ

АУМ-АЛТ-ХХК-ИЙ ӨЛТИЙН  
 УУРХАЙН ДАРГА  
ЖШИЙРЭВДОРЖ